

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН
ХАМТАРСАН ТУШААЛ

2007 оны 11 дугаар
сарын 22 -ны өдөр

Дугаар 106/314

Улаанбаатар
хот

Стандартчилал, тохирлын үнэлгээний
ажил, үйлчилгээний төлбөрийн тухай

"Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай" Монгол Улсын хуулийн 13.2, 16.1, 16.2, 26.1, 26.2 дахь заалт, "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай" Монгол Улсын хуулийн 9.1, 14.2, 20.3 дахь заалт, "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" Монгол Улсын хуулийн 12.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Заавал итгэмжлэлд хамрагдах сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын байгууллага, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг итгэмжлэх ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-г 1 дүгээр хавсралтаар, "Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавал баталгаажуулалтын ажлын төлбөр тооцоолох заавар"-ыг 2 дугаар хавсралтаар, "Бүтээгдэхүүн, үйлчилгээнд "Үндэсний тохирлын тэмдэг" хэрэглүүлэх жилийн төлбөрийн жишиг хэмжээ"-г 3 дугаар хавсралтаар, "Чанар, байгаль орчны удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO 14000) болон холбогдох удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-г 4 дүгээр хавсралтаар тус тус баталж, 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Энэ тушаалын 2 дугаар хавсралтад заасан "Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын ажлын төлбөр тооцоолох заавар"-ын дагуу өөрийн аймагт мөрдөгдөх төлбөрийн хэмжээг аймгийн санхүүгийн хэлтсээр хянуулан тогтоож, мөрдөж ажиллахыг аймгуудын Стандартчилал, хэмжилзүйн төв болон итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Сайн дурын үндсэн дээр тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг өргөдөл, хүсэлт гаргагчтай тохиролцон шийдвэрлэх, гадаад орны тохирлын үнэлгээний байгууллагуудаар гүйцэтгүүлж буй тохирлын үнэлгээний ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг гэрээний үндсэн дээр харилцан тохирч мөрдүүлэхийг Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв (Г.Гантөмөр)-д зөвшөөрсүгэй.

4. Баталгаажуулалтын зөвлөл, "Хэмжилзүйн техникийн зөвлөлийн гишүүд, орон тооны бус шинжээч, аудитор, үнэлгээний мэргэжилтэн болон сургагч багш нарын ажлын хөлс, бусад зардлыг гүйцэтгэсэн төлбөрт болон гэрээт ажил, үйлчилгээний өөрийн орлогоос санхүүжүүлж байхыг Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв /Г.Гантөмөр/, аймгийн Стандартчилал, хэмжилзүйн төв, итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын удирдлагуудад тус тус зөвшөөрсүгэй.

5. Дээр зааснаас бусад стандартчилал, тохирлын үнэлгээний ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэрэглэгч болон үйлчлүүлэгчидтэй тохиролцон гэрээний үндсэн дээр шийдвэрлэж байхыг Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв (Г.Гантөмөр)-д зөвшөөрсүгэй.

ШАДАР САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЭНХСАЙХАН

САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ
Н.БАЯРТСАЙХАН

Заавал итгэмжлэлд хамрагдах сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын байгууллага, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг итгэмжлэх ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээ

№	Төлбөрийн хэлбэр	Төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)
1.	Итгэмжлэлийн өргөдөл, баримт бичигт дүн шинжилгээ хийх буюу өргөдлийн төлбөр	50000
2.	Газар дээр нь үнэлгээ хийх үйлчилгээний төлбөр (нэг үнэлгээний ажилтны ажилласан нэг хүн-өдөрт)	50000
3.	Итгэмжлэлийн гэрчилгээ, тэмдэг хэрэглэсний болон итгэмжлэлийн байгууллагаас үзүүлэх дагалдах үйлчилгээний жилийн төлбөр. Үүнд: 3.1 А бүлгийн лаборатори 3.2 Б бүлгийн лаборатори 3.3 В бүлгийн лаборатори 3.4 Г бүлгийн лаборатори 3.5 Баталгаажуулалт буюу хяналтын үйл ажиллагааны 3000000 төгрөг хүртэл жилийн орлоготой баталгаажуулалт болон хяналтын байгууллага 3.6 3000001-10000000 төгрөгийн жилийн орлоготой баталгаажуулалт болон хяналтын байгууллага 3.7 10000001 төгрөгөөс дээш жилийн орлоготой баталгаажуулалт болон хяналтын байгууллага	50000 160000 430000 650000 200000 500000 750000
Үйлчлүүлэгч байгууллага нь итгэмжлэлийн үнэлгээний ажлын хэсгийн замын зардлыг хариуцна.		

Тайлбар 1: А бүлгийн лаборатори -Орон нутагт хяналт, тохирлын баталгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулсан сорилтын, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын, мал эмнэлэг ариун цэврийн, эмнэлгийн онош зүйн лаборатори;

Б бүлгийн лаборатори – А бүлэгт хамрагдахгүй бөгөөд зөвхөн нэг төрлөөр сорилт, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт гүйцэтгэдэг лаборатори;

В бүлгийн лаборатори - А бүлэгт хамрагдахгүй бөгөөд 2-3 төрлөөр сорилт, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт гүйцэтгэдэг лаборатори;

Г бүлгийн лаборатори - А бүлэгт хамрагдахгүй бөгөөд 4 ба түүнээс олон төрлөөр сорилт, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт гүйцэтгэдэг лаборатори.

Тайлбар 2: Орон нутаг дахь хяналт, тохирлын баталгааны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулсан сорилтын, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын, мал эмнэлэг ариун цэврийн, эмнэлгийн онош зүйн лабораториудад үзүүлэх итгэмжлэлийн ажил, үйлчилгээний төлбөрийг уг байгууллагын санхүүгийн байдалтай уялдуулан 40 хүртэл хувиар хөнгөлнө.

Тайлбар 3: Итгэмжлэлийн ажил, үйлчилгээнд шаардагдах зардлыг итгэмжлэгдэх тухайн байгууллага жилийн төсөвтөө тусгана.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАЛ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ТӨЛБӨР
ТООЦООЛОХ ЗААВАР

1. Хамрах хүрээ

1.1 Энэхүү баримт бичиг нь "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай" Монгол Улсын хууль, олон улсын стандарт, баримт бичгийн дагуу явуулах бүтээгдэхүүн, үйлчилгээний заавал баталгаажуулалт, нийлүүлэгчийн мэдэгдлийн бүртгэлийн ажлын төлбөрийн ерөнхий журмыг тогтооно.

1.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээнд "Үндэсний тохирлын тэмдэг", "Эко тэмдэг" хэрэглүүлэх зэрэг сайн дурын баталгаажуулалтын үнэлгээний ажлын төлбөрийг тогтооход энэхүү зааврыг жишиг болгон ашиглаж болно.

2. Ажлын төлбөр тооцоолох зарчим

2.1. Бүтээгдэхүүний заавал баталгаажуулалтын төлбөрийг дараахь зарчмын дагуу тогтооно.

2.1.1 баталгаажуулалтын ажлын төлбөр нь тухайн ажлыг гүйцэтгэж буй шинжээчийн хөдөлмөр зарцуулалттай уялдсан байх;

2.1.2 баталгаажуулалтын ажлын төлбөрийг холбогдох ажлыг гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн уг ажлын эцсийн үр дүнд үндэслэн гаргасан шийдвэрээс үл хамааран төлж байх;

2.1.3 заавал баталгаажуулалтын ажлын ашигт ажиллагааны түвшин 10.5 хувиас хэтрэхгүй байх.

2.2. Бүтээгдэхүүний заавал баталгаажуулалт болон магадлах хяналтын ажилд татан оролцуулж байгаа шинжээчдийн ажлын хөлсийг өөрийн ажилтнуудын хөдөлмөрийн хөлсний нөхцөлтэй уялдуулан тухайн баталгаажуулалтын байгууллага олгоно.

3. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын ажлын төлбөр

3.1 Заавал баталгаажуулалтын үед тодорхой бүтээгдэхүүнийг баталгаажуулах баталгаажуулалтын байгууллагын нэг хүн-өдрийн зардлыг дараахь томъёогоор тооцно:

$$Б_{ББ(0)} = T \times (1 + (K_{ш} + K_{э}) / 100) \times (1 + A / 100)$$

Үүнд:

$B_{ББ(0)}$ - нэг хүн-өдрийн зардал

T - шинжээчийн нэг өдрийн ажлын хөлс, төг-өөр;

$K_{ш}$ - үйлчилж байгаа хуулиар цалинд тогтоосон шимтгэл, %;

$K_{э}$ - шууд зардлын нийт зардалд эзлэх хувь, %;

A - ашгийн түвшин, %;

3.2 Баталгаажуулалтын i дэх схемийн дагуу тодорхой бүтээгдэхүүний баталгаажуулалтын хөдөлмөр зарцуулалтын хэмжээг хүн-өдрөөр тооцсон "Бүтээгдэхүүнийг заавал баталгаажуулахад баталгаажуулалтын байгууллагаас

гүйцэтгэх ажлын бүрэлдэхүүн, хөдөлмөр зарцуулалтын норматив" хавсралтаас (цаашид "хавсралт" гэнэ) авна.

$$B_{ББ} = B_{ББ(0)} \times t_{ББ} \times K_{ОН}$$

Үүнд:

$B_{ББ}$ - баталгаажуулалтын байгууллагын нийт зардал;
 $t_{ББ}$ - баталгаажуулалтын ажлын хөдөлмөр зарцуулалтын хэмжээ /хүн-өдрөөр/;
 $K_{ОН}$ - орон нутгийн коэффициент.

3.3 Баталгаажуулалтын ажлын төлбөрийг орон нутгийн хүн ам, үйлдвэр, үйлчилгээний тоо хэмжээнээс шалтгаалан дараахь коэффициентээр тооцно.

Үүнд:

Улаанбаатар хот -1;
Дархан - Уул болон Орхон аймаг -0.8;
Бусад аймаг -0.6.

3.4 Магадлах хяналтын үр дүнгээр залруулах эрга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай тохиолдолд баталгаажуулалтын байгууллага нь хавсралтад заасан хөдөлмөр зарцуулалт бүхий ажлыг гүйцэтгэнэ.

3.5 Баталгаажуулалтын ажлын үр дүн эерэг гарсан тохиолдолд гэрчилгээ, тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх баталгаа олгох төлбөрийг авна.

Гэрчилгээ болон тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх баталгаа олгох төлбөр нь тогтмол хэмжээтэй бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байна. Баталгаа олгох зардлыг урьдчилж авна.

Тохирлын гэрчилгээний хуулбарыг нотолж олгоход 1-10 ширхэг бол 0,5 T min хэмжээгээр, 10-аас дээш ширхэг байх тохиолдолд $0,5+0,04x(M-10)x T min$ гэж тус тус тооцно. Үүнд:

M- гэрчилгээний хуулбарын тоо;

T min - хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ.

3.6 Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирж байгаа бүтээгдэхүүний заавал баталгаажуулалтын төлбөрийг мэдүүлэгчээс өгсөн баримт бичгийн бүрэлдэхүүнээс хамааран баталгаажуулалтын байгууллагаас хийж гүйцэтгэсэн бодит ажлын хэмжээгээр тооцно.

3.7 Хэрэв заавал баталгаажуулах бүтээгдэхүүнийг Монгол Улсад хүлээн зөвшөөрсөн гадаад орны гэрчилгээтэй оруулж ирсэн тохиолдолд тус баримт бичгийг бүтээгдэхүүний тохирлын баталгааг гаргах үед нэгэн нотолгос байдлаар хүлээн авах боломжийг авч үзнэ. Ийнхүү авч үзэх ажилбарын хөдөлмөр зарцуулалт нь 0,75 хүн-өдрөөс хэтрэхгүй байна.

о о О о о

Монгол Улсын Шадар сайдын үүрэг гүйцэтгэгч,
Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2007 оны
106/314 дугаар хамтарсан тушаалын 3 дугаар
хавсралт

Бүтээгдэхүүн, үйлчилгээнд "Үндэсний тохирлын тэмдэг"
хэрэглүүлэх жилийн төлбөрийн жишиг хэмжээ

№	Тухайн аж ахуй нэгж, байгууллагын "Үндэсний тохирлын тэмдэг"-тэй бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлэг (жилийн үйлдвэрлэлийн нийлбэр хэмжээ, сая төгрөгөөр)	Төлбөрийн хэмжээ (мян.төг)
1	А бүлэг /100.0 хүртэл/	100.0
2	В бүлэг /100.1-500.0/	250.0
3	С бүлэг /500.1-1000.0/	500.0
4	Д бүлэг /1000.1-2000.0/	1 000.0
5	Е бүлэг /2000-ээс дээш/	2 000.0

ооОоо

Чанар, байгаль орчны удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO 14000) болон холбогдох
удирдлагын тогтолцооны баталгаажуулалтын ажил, үйлчилгээний
төлбөрийн жишиг хэмжээ

№	Ажил, үйлчилгээний нэр, хэмжээ	Төлбөр, /мян.төг/
1	Өргөдөл хүлээн авах, баримт бичигт дүн шинжилгээ хийх <u>Тухайн байгууллагын ажиллагсадын тоо:</u>	
	1 – 40	70.0
	41 – 100	100.0
	101 – 200	150.0
	201 – 350	220.0
	351 – 550	330.0
	551 – 900	450.0
	901 ба түүнээс дээш	580.0
2	Газар дээр нь аудит явуулах үнэлгээ (аудит) явуулах (нэг хүн/өдөрт)	60.0
3	Магадлах (хяналтын) аудит явуулах (нэг хүн/өдөрт)	60.0
4	Гэрчилгээ эзэмшүүлж, ISO 9001, ISO 14000 болон холбогдох стандартуудын тэмдэглэгээ хэрэглүүлэх үйлчилгээний үнэ (жилд) <u>Тухайн байгууллагын ажиллагсадын тоо:</u>	
	1 – 40	85.0
	41 – 100	125.0
	101 – 200	185.0
	201 – 350	275.0
	351 – 550	410.0
	551 - 900	620.0
	901 ба түүнээс дээш	930.0
5	Дахин үнэлгээ явуулах Өргөдөл хүлээн авах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, газар дээр нь үнэлгээ явуулах үйлчилгээний нийт үнийн 85 хувиар тооцно.	

Жич: Үйлчлүүлэгч байгууллага нь үнэлгээ явуулах аудитын багийн замын
зардал, байр, хоолны зардлыг хариуцна.

о о о О о о о